Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Гантулга Наранбаатар

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх | | | | | | | |
| 1 | Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ. | Хяналт шалгалтад эрэмбэ, чансааны үзүүлэлтээр сонголт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь | - | Хяналт шалгалтад эрэмбэ, чансааны үзүүлэлтээр сонголт хийсэн объектын тоо-5 Зөрчил арилгуулалтын хувь-20% | Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хийх хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/50 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулах, дүгнэх удирдамжид заасан аргачлалын дагуу төрийн болон төрийн бус өмчийн 77 их, дээд сургуульд шалгуур үзүүлэлтэд туссан сургалтын орчны нөхцөл байдлыг үнэлж, тайлан, тоон мэдээллийг нэгтгэн боловсруулж танилцуулсан. | | |
| 2 | Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудасны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангал ажиллана. | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо | Мэдээллийн сан - 0 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн - 2 Хамрагдсан улсын байцаагч - 60 | Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 1 Хамрагдсан улсын байцаагч - 40 | Цахим хяналтын нэгдсэн систем ашиглахтай холбогдуулан хяналтын хуудасны мэдээллийг шилэн хяналтын цахим системд оруулах ажил хийгдэж, хяналт шалгалтын бүртгэл мэдээллийг шилэн хяналтын цахим системд оруулах арга зүйн цахим сургалтад хамрагдсан. Салбарын хяналтын газраас боловсролын сургалтын байгууллагын мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэхтэй холбогдуулан улсын байцаагчдын нэгдсэн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжил арга зүйн сургалтаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. | | |
| 3 | Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө. | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 4 | Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 2 | Боловсролын багц хуулийг дагаж гарах боловсролын сургалтын байгууллагад холбогдох шинэчилсэн дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллаж байна. Тухайлбал аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газрын ажиллах дүрэм журам, Дээд боловсролын сургалтын байгууллагад холбогдох цахим бүртгэлийн шинэчилсэн дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллалаа. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 98% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 4 | Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх | Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин | Шалгалт хийсэн объектын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 73% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 75% | Шалгалт хийсэн объектын тоо - 2 Зөрчил арилгуулалтын хувь - 25% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 30% | БШУЯ-ны 2024 оны төлөвлөгөө, Салбарын хяналтын газрын 2024 оны төлөвлөгөөнд туссан дээд боловсролын сургалтын байгууллагад хийх хяналт шалгалт Салбарын хяналтын | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын даргын баталсан 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 03-00/03 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу явагдаж байна. Хяналт шалгалтын ажил үргэлжилж байна. Хавсралт: 1 файл | | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 5 | Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх | Зөрчил арилгуулалтын хувь | Зөрчил арилгуулалтын хувь - 60% | Зөрчил арилгуулалтын хувь - 65% | Элсэлтийн ерөнхий шалгалт 2024 оны 7 сард зохион байгуулах болсон тул урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан батлуулах бэлтгэл ажлыг хангаж, улсын байцаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | 6-р сар | Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 6 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 95% | Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - Тухай бүр Зөрчил арилгуулалтын хувь - 40% | - БШУ-ы сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар баталсан "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 98% Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх", БШУ-ы сайдын 2024 оны А/212 дугаар тушаалаар баталсан "Ажлын хэсэг байгуулах, дүгнэлт гаргах" удирдамжийн хүрээнд нийт 77 дээд боловсролын сургалтын байгууллагад эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, цаашид авах хэмжээний санал дүгнэлт боловсруулан танилцуулсан. - Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн 13 албан бичиг, 7 хүсэлт өргөдөл гомдол, 6 иргэний боловсролын баримт бичигт шалгалт хийж, нийт хариутай 6 албан бичиг, 7 өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан. | сар, 11-р сар, 12-р сар | даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 7 | Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн | Хамрагдсан объектын тоо Хууль тогтоомжийн хэрэгжилт | - | Хамрагдсан объектын тоо-64 Хууль тогтоомжийн хэрэгжилт-45% | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/50 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэлт гаргах | | | | хэсэг боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хүрээнд 77 их, дээд сургуулиудад хяналт шалгалт хийгдэж, тайлан, дүн мэдээллийг боловсруулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх санал дүгнэлтийг холбогдох газруудад танилцуулж ажиллалаа.<br>Хавсралт: 1 файл | | үнэлгээ: 96%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.2. Шинжлэх ухааны чиглэлээр хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх хяналт тавих | | | | | | | |
| 8 | Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь | - | Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 30% | Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд хийх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/50 дугаар тушаалаар | 3-р сар, 4-р сар, 5-р сар | Өөрийн үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 75%<br>Нэгжийн даргын үнэлгээ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажил 3, 4, 5 дугаар саруудад үргэлжлэн явагдсантай холбогдуулан 2024 оны 9, 10 дугаар сарuудад хийхээр төлөвлөсөн. Салбарын хяналтын газрын даргын баталсан 03-00/14 дугаартай удирдамжийн дагуу Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хийх бэлтгэл ажлыг хангаж байна. Хавсралт: 1 файл | | төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 9 | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, | Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ Зөрчил арилгуулалтын хувь | Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ - 5 Зөрчил арилгуулалтын хувь - 25% | Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо -1 Зөрчил арилгуулалтын хувь - 10% | Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан технологийн салбарт хэрэгжиж буй судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явцад урьдчилан сэргийлэх | 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 40% Нэгжийн даргын үнэлгээ: 70% Нэгжийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргана. | | | | хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/50 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажил 3, 4, 5 дугаар саруудад үргэлжлэн явагдсантай холбогдуулан 2024 оны 9, 10, 11 дүгээр саруудад хийхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна. | | даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 3.1. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | |
| 10 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах | Хууль дүрэм журмын хүрээнд төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | Боловсрлуулж батлуулсан төлөвлөгөөний тоо - 1 | Боловсрлуулж батлуулсан төлөвлөгөөний тоо - 1 | Төрийн албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Салбарын хяналтын газрын 2024 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, газрын даргаар батлуулсан. | 1-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байдал: 100% |
| 11 | Төлөвлөгөөний биелэлт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Гаргасан тайлан, мэдээний тоо - 10 | Гаргасан тайлан, мэдээний тоо - 5 | - Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны төлөвлөгөөнд салбарын хяналтын газраас хийгдэх арга хэмжээнд санал тусгуулж,төрийн жинхэнэ албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгжийн даргаар батлуулан, хийсэн ажлын тайланг сар бүр, хагас жилээр тайлагнан ажиллаж байна. - Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд 2 санал, аймаг, нийслэлийн БШУГ-ын ажиллах журмын төсөлд 2 санал, Дээд боловсролын сургалтын байгууллагын цахим мэдээллийн бүртгэлийн журамд 3 санал хүргүүлсэн. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 12 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан | Хуулийн хугацаанд үнэн зөв тайлагнасан байна. | ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд батлагдсан маягтын дагуу тайлагнасан тоо - 1 | ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд батлагдсан маягтын дагуу тайлагнасан тоо - 1 | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, түүнд | 1-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сэргийлэх тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | | | | нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргаж, холбогдох эрх бүхий албан тушаалтанд тайлагналаа. | | Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 13 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль түүнд, нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж, үйлдсэн баримт бичгийг ангилан төрөлжүүлж, байгууллагын архивт шилжүүлэх. | Хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд архивын нэгжийг бүрдүүлж хүлээлгэн өгсөн байна. | Архивт шилжүүлсэн баримтын тоо - 0 | Архивт шилжүүлсэн баримтын тоо - 3 | Салбарын хяналтын газрын албан хаагчдын 2023 онд үйлдсэн хяналт шалгалтын баримт бичгийг архивлан бүрдүүлэх ажил хийгдэж байна. | 2-р сар | Өөрийн үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 85%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50% |
| 14 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг шийдвэрлэх | Хуулийн хугацаанд өргөдөл гомдол, албан бичгийг шийдвэрлэсэн байна. | Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо - 11 Шийдвэрлэлтийн хувь - 100% | Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо - Тухай бүр Шийдвэрлэлтийн хувь - 100% | Боловсрол, шинжлэх ухааны яамны бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль,Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, хяналт тавих, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хуульд заасан ил тод байдлыг ханган ажиллах, хориглолт, хязгаарлалтыг зөрчихгүй байхад анхааран ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн хугацаанд өргөдөл гомдол 7 ирснээс 7 өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн байна. Нийт 13 албан бичиг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэн 6 албан бичигт хариу хүргүүлсэн байна. Нийт 13 албан бичгээр хүсэлт, өргөдөл, гомдол, албан бичгийн хариуг хүргүүлж ажилласан байна. | | хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 15 | Цаг үеийн нөхцөл | Цаг хугацаанд нь | Гүйцэтгэсэн арга | Хэрэгжүүлсэн арга | - Боловсролын | 2-р сар, 3- | Өөрийн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх | чанартай хийж гүйцэтгэсэн байна. | хэмжээ - 6 Гүйцэтгэлийн хувь - 100% | хэмжээ -Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100% | ерөнхий хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль эцэслэн батлагдсантай холбогдуулан Дээд боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсыг Дээд боловсролын удирдлага, зохицуулалтын газар, хууль, эрх зүйн хэлтэс болон аймаг, нийслэлийн улсын байцаагчдаар хэлэлцүүлэн санал авч, хуульд нийцүүлэн шинээр дахин боловсруулж, БШУ-ны сайдын 2024 оны 04 сарын 02-ны А/150 тоот тушаалаар баталлаа. - БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/50 дугаар тушаалаар байгуулагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хэсэг - БШУ-ны сайдын 2024 оны "Магадлан | р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгах ажлын хэсэг байгуулах тухай" А/127 дугаар тушаалаар байгуулагдсан зөвшөөрөл олгоход хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг магадлан шалгах ажлын хэсэг - БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, дүгнэлт гаргах тухай" А/212 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан.<br>Хавсралт: 4 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

<table>
<tr><th rowspan="3">№</th><th rowspan="2">Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ</th><th rowspan="2">Шалгуур үзүүлэлт</th><th colspan="5">Гүйцэтгэлийн түвшин</th></tr>
<tr><th>Суурь түвшин</th><th>Хүрэх түвшин</th><th>Хүрсэн түвшин / биелэлт</th><th>Эхэлсэн, дууссан хугаца</th><th>Биелэлтийн хувь</th></tr>
<tr><td>1</td><td>2</td><td>3</td><td>4</td><td>5</td><td>6</td><td>7</td></tr>
<tr><td colspan="8">4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Мэргэжил, боловсролоо /ахлах мэргэжилтэн/ дээшлүүлэх чиглэлээр танхимын болон цахим сургалтуудад хамрагдана. | Тухайн чиглэлээр зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдсан байна. | Хамрагдсан сургалтын тоо-4 | Албан хаагчийн мэргэжлийн ур чадвар дээшилсэн байна - Тухай бүр | -Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (шилэн хяналт) ашиглалтад орж байгаатай холбогдуулан хяналтын улсын байцаагч нарт зориулсан цахим сургалтанд хамрагдсан. -Аймаг, нийслэлийн Боловсролын хяналтын улсын /ахлах/ байцаагчдад зориулсан хяналт шалгалтын арга зүй, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ сэдэвт сургалтад хамрагдсан. -НПГ-аас зохион байгуулсан Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээ, анхаарах асуудлын талаар "ЗӨРЧИЛ, ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА, ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ПРАКТИК ШААРДЛАГА, ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭ" сэдэвт сургалтад хамрагдсан. -Байгууллагын 7 хоног бүр зохион байгуулж буй мэдээллийн цагт бүрэн хамрагдаж, холбогдох мэдээ мэдээллийг авч байна | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100% |
| 2 | Боловсрол, шинжлэх ухааны салбарын чиглэлээр шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, дүрэм, журмуудыг уншиж судална. | Шинээр болон шинэчлэгдэн батлагдсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг уншиж, судлан, | - | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна - Тухай бүр | Боловсрол, шинжлэх ухааны яамны бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсролын ерөнхий хууль болон хамт батлагдан гарсан боловсролын багц хууль, Шинжлэх ухаан, технологийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглана. | | | тухай хууль, шинээр болон шинэчлэгдэн гарсан холбогдох дүрэм журмын талаар уншиж судлан, хяналтын үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. | сар, 12-р сар | |
| 3 | Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах мэдлэг олгох худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох цахим сургалтад хамрагдана. | Худалдан авах ажиллагааны талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна. | - | Албан хаагчийн хууль эрх зүйн мэдлэг сайжирсан байна | 2024.02.23-ны өдөр зохион байгуудагдсан Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн сургалтад хамрагдсан. | 3-р сар, 4-р сар, 5-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 80% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Салбарын хяналтын газрын ахлах мэргэжилтэн, Гантулга Наранбаатар /................................................./ Огноо: .........................